

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА  
2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр

## БУДГИЙН МАШИН НИЙЛҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод аэродромын хучилттай элементүүдийг будах будгийн машин нийлүүлэх техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

### 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.
- Техникийн тодорхойлолтыг хангасан талаар нотлох баримт бичиг /үйлдвэрлэгчийн бичиг баримт, гарын авлага/ ирүүлэх.
- Техникийн бичиг баримт нь Англи, Монгол хэл дээр байна

### 3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үзүүлэлтүүд	Хэмжээ
Техникийн үзүүлэлт	Технологи ажиллагаа	Агааргүй /airless/буюу өндөр даралтаар шүршдэг байх
	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	3-аас их
	Шатахууны төрөл	Авто бензин
	Ажлын даралт, бар	200-аас их, даралтын хэмжүүртэй байх
	Будах өргөн, см	3-аас 30
	Будгийн зарцуулалт, л/мин	2-оос их
	Будгийн бууны тоо	1
	Будгийн хошуу	Будах хэсгийн өргөнд тохируулан хошууг солих боломжтой байх.
	Хөдлөх бүрэлдэхүүн	Гараар түрж явахад зориулагдсан, урд хөтлөх 1 болон арын 2 дугуйтай, хөдөлгөөн жигд, тогтвортой байх.
	Хэмжээ, см	160 x 120 x 90 -ээс ихгүй.
	Ажлын жин, кг	70-аас 115

		Түрэх бариул	2 байх ба будаг шүрших гар удирдлагатай байх.
3.2  Ашиглалтын үзүүлэлт	Зориулалт		Аэродромын хучилттай элементүүдийн будган тэмдэглэгээг шинээр будах болон сэргээх.
	Чанарын түвшин		Аэродромын хучилттай элементүүдийн будган тэмдэглэгээг будах төхөөрөмж нь Larius, Hofmann маркийн болон түүнтэй дүйцэх, шинэ байна. Техникийн үйлчилгээ явуулахад хялбар, хамгийн сүүлийн үеийн технологи ашиглан хийгдсэн байх.
	Туршилт, тохирогоо		Тендерт шалгарсан нийлүүлэгч байгууллага нь төхөөрөмжийг ажиллуулж, туршиж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгнө. Мөн ашиглалтын гарын авлага, техник үйлчилгээ засварын ажлын зааврыг Монгол, Англи хэл дээр өгнө.

#### 4. ХҮЛЭЭН АВАХ

- 4.1 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон материалыг шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр хүлээн авсанд тооцно.
- 4.2 Баталгаат засварын хугацаа нь бараа хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 3 сар байна.
- 4.3 ИНҮТ, Аэродром, гэрэл суултын албанад нийлүүлэх.

#### Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Аэродром, гэрэл суултын албаны дарга,  
Үнэлгээний хорооны дарга:

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”  
Төрийн бус байгууллагын тэргүүн,  
Үнэлгээний хорооны гишүүн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Хөрөнгө оруулалт, захиалгачийн албаны  
Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,  
Үнэлгээний хорооны нарийн бичиг:

И.Амарсанаа

Б.Мэндсайхан

А.Баянжаргал